

Д/д	Оролцогчийн тодруулга	Захиалагчийн хариулт
1	ГТН. А. Гэрээний Ерөнхий нөхцөл (ГЕН)-д тусгагдах мэдээлэл: 1.4.2. Асуулт: FIDIC гэрээнд ойлголцлын зөрүү гарахад Англи хэл дээрх хувилбарыг баримталдаг бөгөөд гэрээний хэлийг “Англи” болгож засах хэрэгтэй	ТЖББ-ийн VI бүлэг “Гэрээний нөхцөл” хэсэгт олон улсын тендер шалгаруулалтыг харгалзан Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ноос эрхлэн гаргадаг Зөвлөх үйлчилгээний гэрээ (white book, 2017)-ний нөхцөлийг хэрэглэхээр заасан. Тус бүлгийн Гэрээний тусгай нөхцөлийн А хэсгийн 1.4.2-т гэрээнд баримтлах албан ёсны хэл нь Монгол болон Англи хэл буюу хос хэл (dual language) байх бөгөөд зөрүү үүсвэл Монгол хэлийг баримтлахаар заасан болно. ТЖББ-ын ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.
2	ГТН. В. Гэрээний Ерөнхий нөхцөлд оруулсан нэмэлт болон өөрчилсөн заалтууд 2.1 Мэдээлэл: Асуулт: Захиалагчаас гаргаж өгсөн мэдээллийн тодорхой байх тухай хариуцлагыг Зөвлөхөд дамжуулж байгаа заалт учир FIDIC Ажил гүйцэтгэх гэрээний Silver Book-ний түвшний өндөр эрсдэлийг Зөвлөх талд өгч байна. Зөвлөх (PMC) нь Захиалагчаас өгсөн мэдээлэл, материалыг үндэслэн ажлыг хэрэгжүүлэх тул энэхүү агуулгыг устгах эсхүл үндсэн FIDIC гэрээний заалтыг нь сэргээх хэрэгтэй.	ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.
3	ГТН. А. Гэрээний Ерөнхий нөхцөлд оруулсан нэмэлт болон өөрчилсөн заалтууд 2.2 Шийдвэр: Асуулт: Зөвлөх (PMC) нь ажлыг хэрэгжүүлэхдээ Захиалагчтай зөвшилцөж, Захиалагчаар баталгаажуулсны дараа ажлыг явуулсан зүйл дээр ч гэсэн хариуцлагыг бүрэн хүлээнэ гэдэг нь Зөвлөх талд хязгааргүй хариуцлагыг үүрүүлэх гэсэн агуулга тул Захиалагч болон Зөвлөхийн хооронд үл ойлголцох, хүлээн зөвшөөрөхгүй байх заалт байна. Агуулгыг устгах эсхүл үндсэн FIDIC гэрээний заалтыг нь сэргээх хэрэгтэй.	ТЖББ-ийн VI бүлэгийн “Гэрээний тусгай нөхцөл” хэсгийн 9.1.1-д “Захиалагч нь Зөвлөхийг (a)-аас (d) хэсгүүдэд заасан даатгал, болон мэргэжлийн хариуцлагын даатгалыг (e)-д заасан тусгай шаардлагад нийцүүлэн, Гэрээний үнийн дүнгээс багагүй үнэлгээгээр, Захиалагчийн хүлээн зөвшөөрсөн олон улсын нэр хүнд бүхий даатгалын байгууллагаар даатгуулахыг шаардана” гэж заасан. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.
4	ГТН. А. Гэрээний Ерөнхий нөхцөлд оруулсан нэмэлт болон өөрчилсөн заалтууд 2.3 Туслалцаа: Асуулт: Захиалагчид гарсан зардлын талаарх бодит стандарт норм байхгүй, түүнийг нөхөн	ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн

	төлөх үүргийг Зөвлөхөд шилжүүлж буй заалтын агуулгыг арилгах эсвэл үндсэн FIDIC гэрээний заалтыг нь сэргээх хэрэгтэй.	материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.
5	ГТН. В. Гэрээний Ерөнхий нөхцөлд оруулсан нэмэлт болон өөрчилсөн заалтууд 3.7 Ажилтнуудад өөрчлөлт оруулах: Асуулт: Шаардлагатай бол Захиалагч ажилтнуудын тоог нэмэх, хасахыг шаардаж холбогдох бүхий л зардлыг Зөвлөх хариуцахаар заасан байгаа бөгөөд Зөвлөх (PMS)-ийн ажлын үнэ нь оролцох ажилтнуудын тоотой шууд холбоотой байгаа тул зохисгүй агуулга тул устгах нь зүйтэй.	ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.
6	ГТН 4.4.1: Тодруулга: Ажлын хуваарьтай холбоотой цаг хугацаа хойшлох шалтгааныг тодорхойлох нь хүндрэлтэй бөгөөд Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой гэрээний удирдлагаар хангах (ажлын график удирдах) хүртэл бүх хариуцлагыг Зөвлөх хүлээнэ гэдэг нь зохисгүй тул арилгах нь зүйтэй	ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ. Энэ заалт нь Гүйцэтгэгчийн буруутай үйлдлээс хамааралтай бөгөөд хариуцлагын хязгаарын дотор яригдах асуудал болохыг анхаарна уу.
7	ГТН 7.1.1: Асуулт: Дээд хэмжээнд ажлын хамрах хүрээг гэрээний үнийн дүнгээр хязгаарлах заалт тул ‘Ажлын үнэ нь гэрээний үнийн дүнд хүрсэн тохиолдолд гэрээг зогсоох эсхүл гэрээг цуцлах боломжтой’ гэж засах нь зүйтэй	ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.
8	ГТН 7.1.4: Асуулт: Гэрээнд урьдчилгаа төлбөр олгодог нийтлэг ойлголт гэж харж байгаа хэдий ч, 1-р бүлгийн ТШЗ. 37.1. ‘Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй’ гэж заажээ. Олгох эсэх талаарх агуулгыг тодорхой болгож өгөх	Төлбөрийн нөхцөлийг хэлэлцээрийн шатанд шийдвэрлэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар урьдчилгаа төлбөр олгох тохиолдолд тендерт оролцогч урьдчилгаа төлбөрөөс багагүй дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргахаар заасан. Урьдчилгаа төлбөр өгөхөөр тохиролцох нөхцөлд хүлээлгэн өгөх бичиг баримт (deliverables) болон ажлын үе шаттай (milestone) уялдуулж, эргэн төлөгдөх нөхцөлийг тодорхойлох (amortization) шаардлагатай.
9	ГТН 7.2.1: Асуулт: Ажлын үр дүнгээр биш гэрээний үүргийн гүйцэтгэлтэй уялдуулж олгох талаар заасан байгаа бөгөөд хэмжих боломжгүй үнэлгээний хэмжүүрийг тавих нь маргаан үүсгэх магадлалтай тул агуулгыг илүү тодорхой болгох мөн Гүйцэтгэлийн төлбөр олгох нөхцөлийг тодорхой болгох хэрэгтэй	Төлбөрийн нөхцөлийг хэлэлцээрийн шатанд шийдвэрлэнэ. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн

		<p>материалд ирүүлнэ.</p> <p>Гэрээний төсөл нь ажлын үр дүн (Deliverables, Milestone e.g)-тэй шууд уялдсан нэгдсэн үнэ (Lump sum)-ийн гэрээ байхаар бэлтгэгдсэн. Гэхдээ төслийн онцлогоос шалтгаалан та бүхэнд Lump sum болон Time based нөхцөлийг холимог санал байгаа тохиолдолд ирүүлж болно.</p>
10	<p>ГТН 8.1.4: Асуулт: Ажил гүйцэтгэх хугацааг сунгах хариуцлагыг Захиалагч шийдэж, Зөвлөх гэрээний үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс шалтгаалсан гэж үзсэн бол тийнхүү хойшилсноос үүсэх хохирол, зардлыг Зөвлөхөөр төлүүлэх гэдэг нь бодит шийдвэр гаргахад хүндрэлтэй тул зохимжгүй өгүүлбэр тул агуулгыг арилгах нь зүйтэй</p>	<p>Төлбөрийн нөхцөлийг хэлэлцээрийн шатанд шийдвэрлэнэ.</p> <p>ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.</p>
11	<p>ГТН 8.6: Асуулт: Төслийн гол үе шатууд амжилтгүй болох, хугацаандаа хэрэгжээгүй байх тохиолдолыг зөвлөхийн хариуцлага гэх нь зохимжгүй байна. Жишээ нь: Ажлын даалгаврын (6) Төслийн үе шат, Үе шат 1 дэх ТЭЗҮ, эскиз зураг, тендерийн баримт бичиг боловсруулах, EPC гүйцэтгэгч сонгон шалгаруулалтыг 6 сарын дотор хийх боломжгүй хугацаа юм. Төслийн үе шат тус бүрээр төлөвлөгөөг шалгарсан газартай зөвшилцөж гэрээлэх хэрэгтэй болохоор өгүүлбэрийг засах эсхүл FIDIC гэрээний заалтаар засах хэрэгтэй.</p>	<p>ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.</p> <p>Техникийн тодорхойлолт (Үйлчилгээний даалгавар)-ын В(6) Төслийн үе шат-д “Төслийн менежментийн зөвлөх нь суурь судалгааны эскиз зураг боловсруулах үе шатанд богино хугацаанд өндөр бүтээмжтэй ажиллах зорилт тавин ажиллах зорилтыг дэвшүүлэн төслийн үе шатыг эцэслэн тогтооно.” гэж заасан.</p>
12	<p>ГТН 10. Маргаан шийдвэрлэх, Арбитр: Асуулт: Олон улсын гэрээнд нийтлэг Сингапур дахь Арбитраар дамжуулан маргааныг шийдвэрлэх саналтай байгаа бөгөөд Монгол улсын хуулийн орчин нөхцөлийг харгалзан үзэхэд FIDIC гэрээний үндсэн заалтыг тэр хэвээр нь ашиглах нь зүйтэй.</p>	<p>ТЖББ-ийн VI бүлэг “Гэрээний нөхцөл” хэсэгт олон улсын тендер шалгаруулалтыг харгалзан Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ноос эрхлэн гаргадаг Зөвлөх үйлчилгээний гэрээ (White book, 2017)-ний нөхцөлийг хэрэглэхээр заасан. Тус бүлгийн Гэрээний тусгай нөхцөлийн В хэсгийн 10-т “Маргаан шийдвэрлэх, арбитр: маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд шилжүүлж, эцэслэн шийдвэрлүүлнэ гэж заасан. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.</p>

13	В. “Метро төслийн” танилцуулга (3) Төслийн төлөвлөгөө Трассын зураг: Асуулт: Трассын дагууд тэмдэглэсэн өртөөний тоо хэмжээ (14 stations) болон байршлыг эцэслэн тогтоосон байгаа юу? Эсхүл Зөвлөх өртөөний тоо хэмжээ байршлыг өөрчилж болох эсэх?	Урьдчилсан ТЭЗҮ-г үндэслэн өртөөний тоог 14 гэж тодорхойлсон бөгөөд Техникийн тодорхойлолт (Үйлчилгээний даалгавар)-ын В (3) Төслийн төлөвлөгөө хүснэгтэд “...өртөөний тоо болон байршлыг суурь судалгааг үндэслэн тодорхойлно” гэж заасан.
14	В. “Метро төслийн” танилцуулга (5) Төслийн үр дүн 3 дахь заалт: Асуулт: Гүйцэтгэх хугацааг засах мөн шинэчлэнэ гэвэл Зөвлөх (PMC) төслийн ажлыг дуусгах хугацаа гэрээний нөхцөлөөс өөрөөр сунгагдаж ч болно хэрэв ийм тохиолдолд Зөвлөхийн ажлын төлбөрийг нэмэлтээр өгөх үү?	Гэрээний төсөл нь ажлын үр дүн (Deliverables, Milestone e.g)-тэй шууд уялдсан нэгдсэн үнэ (Lump sum)-ийн гэрээ байхаар бэлтгэгдсэн. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ. ТЖББ-ийн Өгөгдлийн хүснэгтийн “ТШЗ 21.4-т” Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахаар заасан бөгөөд тохируулгын тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн “11.11-т Захиалагч гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэрээний үнийг тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлалыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэснийг анхаарах нь зүйтэй.
15	В. “Метро төслийн” танилцуулга (6) Төслийн үе шат Хүснэгт В-2: Үе шат -1 Асуулт: Үе шат – 1-д заасан 6 сарын хугацаанд ТЭЗҮ шинэчлэх, эскиз зураг гаргах, ЕРСгүйцэтгэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулах ажлыг дуусгана гэхэд хангалтгүй хугацаа юм. Тиймэс гэрээлэгчээр шалгарсан байгууллага гэрээний зөвшицөл хийхдээ 1 дэх үе шатны хугацаа болон нийт ажлын төлөвлөгөөг зөвшилцөн засаж өөрчлөх зохицуулалт хийх боломжтой юу?	Техникийн тодорхойлолт (Үйлчилгээний даалгавар)-ын В(6) Төслийн үе шат-д “Төслийн менежментийн зөвлөх нь суурь судалгааны эскиз зураг боловсруулах үе шатанд богино хугацаанд өндөр бүтээмжтэй ажиллах зорилт тавин ажиллах зорилтыг дэвшүүлэн төслийн үе шатыг эцэслэн тогтооно.” гэж заасан.
16	В. “Метро төслийн” танилцуулга (6) Төслийн үе шат Хүснэгт В-2: Үе шат -3,4 Асуулт: Зөвлөх үйлчилгээний ажлын үе шатны барилга угсралтын ажилд хяналт тавьж дуусах хугацаа (2029 оны 8-р сар)-тай ашиглалт ба засвар арчлалтын эхлэх хугацаа (2028 оны 9-р сар) нь хоорондоо таарахгүй 1 жилээр зөрөөд байгаа тул	Техникийн тодорхойлолт (Үйлчилгээний даалгавар)-ын В(6) Төслийн үе шат-д “Төслийн менежментийн зөвлөх нь суурь судалгааны эскиз зураг боловсруулах үе шатанд богино хугацаанд өндөр бүтээмжтэй ажиллах зорилт тавин ажиллах зорилтыг дэвшүүлэн төслийн үе шатыг эцэслэн тогтооно.” гэж заасан.

	<p>үүнийг засах юм бол Зөвлөхийн ажил дуусах хугацаа нь 2031 оны 8-р сар 7 жил (87сар) болж өөрчлөгдөж таарна. Үүнээс хамааран, Зөвлөхийн ажлын хугацаа 1 жилээр сунгагдаж байгаа тул гэрээний үнийн дүнг өөрчлөх мөн нэмэгдэх эсэх?</p>	<p>ТЖББ-ийн Өгөгдлийн хүснэгтийн “ТШЗ 21.4-т” Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахаар заасан бөгөөд тохируулгын тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн “11.11-т Захиалагч гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэрээний үнийг тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлалыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэснийг анхаарах нь зүйтэй.</p>
17	<p>D.1 үе шат: Суурь судалгааны эскиз болон тендерийн баримт бичгийг боловсруулах (3) Зураг төслийн ажил 1. Инженерийн бэлтгэл ажлын судалгаа Асуулт: Депо байрлах байршлыг шинэ нисэх рүү явах замд биш өөр газарт тодорхойлох тохиолдолд шинэ нисэх хүртэл трассыг сунгах шаардлагагүй гэж тендерийн санал боловсруулж болох эсэх? Тэгэхгүй бол Шинэ нисэх буудал хүртэл трассыг сунгах талаар судлах нь ажлын үндсэн трассд орсон гэж ойлгож, судлах тухай агуулгыг техникийн саналд оруулах хэрэгтэй эсэх ?</p>	<p>Саналыг тайлбарын хамт Захиалагчид хүргүүлэх бөгөөд Захиалагчтай зөвшилцөн эцэслэн тогтооно.</p>
18	<p>6. D.1 үе шат: Суурь судалгааны эскиз болон тендерийн баримт бичгийг боловсруулах (3) Зураг төслийн ажил 2. Суурь судалгааны эскиз Асуулт: "Хүйтэн бүсийн технологи (Cold Zone Technology)"-ийг ашиглан метрог барина гэсэн техникийн тодорхойлолт дахь тодорхой агуулгыг тайлбарлах мөн "Хүйтэн бүсийн технологи"-ийг хангахын тулд Зөвлөх нь ажилдаа мөрдөх зүйлийн талаарх агуулгыг санал болгох боломжтой юу?</p>	<p>"Хүйтэн бүсийн технологи (Cold Zone Technology)"-ийг хангахын тулд Зөвлөх нь ажилдаа мөрдөх зүйлийн талаарх агуулгыг санал болгох боломжтой юм.</p>
19	<p>D.1 үе шат: Суурь судалгааны эскиз болон тендерийн баримт бичгийг боловсруулах (3) Зураг төслийн ажил ТЭЗҮ шинэчлэх Асуулт: Гадаад орнуудад сургалтанд хэдэн удаа, аль зэрэг хугацаагаар хэдэн хүн хамруулах вэ?</p>	<p>Гадаад сургалтад сургах шаардлагатай тооны мэргэжилтний тоо, хугацааг Зөвлөхөөс санал болгож Захиалагчтай зөвшилцөн тодорхойлж, сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллана.</p>
20	<p>D 5. Үе шат: Төслийг ашиглалтад оруулах, зүгшрүүлэх хүлээлгэн өгөх Асуулт: Бүрэн ашиглалтад оруулахын өмнөх туршилтын хөдөлгөөн нь (PMS+EPS+Ашиглалт засвар арчлалтын байгууллага хамтарсан туршилтын хөдөлгөөн) 2030 оны 8 сараас өмнө хийх үү?</p>	<p>Техникийн тодорхойлолт (Үйлчилгээний даалгавар)-ын D.5 (2)-төслийг ашиглалтад оруулахтай холбоотой Зөвлөхийн хийж гүйцэтгэх ажлыг тодорхойлсон бөгөөд төлөвлөсөн хугацаанд туршилтын хөдөлгөөнийг нээхээр төлөвлөсөн.</p>

21	Бүрэн ашиглалтад оруулж зорчигч тээврийг эхлүүлэх огноо нь хэзээ гэж үзэж байна вэ?	Техникийн тодорхойлолт (Үйлчилгээний даалгавар)-ын В(6) Төслийн үе шат-д “Төслийн менежментийн зөвлөх нь суурь судалгааны эскиз зураг боловсруулах үе шатанд богино хугацаанд өндөр бүтээмжтэй ажиллах зорилт тавин ажиллах зорилтыг дэвшүүлэн төслийн үе шатыг эцэслэн тогтооно.” гэж заасан.
22	Тендер шалгаруулалтын 2-р үе шатны баримт бичгийн Хавсралт №6-н үе шат-4 “Ашиглалт, засвар арчлалтын сургал” хэсэгт 7 ажил, үйлчилгээ харин Зөвлөх үйлчилгээний техникийн тодорхойлолт (үйлчилгээний даалгавар)-н D. “Зөвлөх үйлчилгээний ажлын цар хүрээ”-н хүснэгт №5 дахь үе шат-4 “Ашиглалт, засвар арчлалтын сургал” хэсэгт 4 ажил үйлчилгээ байна. 2 баримт бичигт зөрүүтэй мэдээлэл байгаагийн аль нь зөв эсэх?	Тендер шалгаруулалтын 2-р үе шатны баримт бичгийн Хавсралт №6-н үе шат-4 “Ашиглалт, засвар арчлалтын сургалт” хэсэгт тусгасан 7 ажил үйлчилгээг баримтална.
23	ГЕН ий 8.1 ба 8.6 заалтууд дээр хэт захиалагчийн талд тэнцвэргүй заалтууд, зөвхөн Захиалагчийн үзэмжээр ТМЗд хариуцлага үүрүүлэх боломж үүсгэхээр байгаа тул анхаарч үзэхийг хүсье.	ТЖББ-ийн VI бүлэгийн “Гэрээний тусгай нөхцөл” хэсгийн 9.1.1-д “Захиалагч нь Зөвлөхийг (а)-аас (d) хэсгүүдэд заасан даатгал, болон мэргэжлийн хариуцлагын даатгалыг (е)-д заасан тусгай шаардлагад нийцүүлэн, Гэрээний үнийн дүнгээс багагүй үнэлгээгээр, Захиалагчийн хүлээн зөвшөөрсөн олон улсын нэр хүнд бүхий даатгалын байгууллагаар даатгуулахыг шаардана” гэж заасан. ТЖББ-ын ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ үү.
24	Голлох 12 мэргэжилтэнгүүдийн шаардлагыг ирүүлсэн байгаа ч эдгээр ажилчдыг хамгийн багадаа хэдэн сар ажлуулах, нийт ажилчид хэдэн хүн.сар ажиллах шаардлага байхгүй байгаа нь тендерийг хянах, тэнцвэртэй үнээр шударга өрсөлдөх боломжгүй болгож байгааг мөн анхаарч, ОУн жишиг Тендерийн материалаас жишиг авч бэлтгэхийг хүсье. (Жишиг авч болохуйц: https://www.jica.go.jp/Resource/english/our_work/types_of_assistance/oda_loans/oda_op_info/guide/tender/c8h0vm0000aoesst-att/consul_202310.pdf)	Гэрээний хавсралтаар хүн/сар зэрэг мэдээллийг оролцогч өөрөө ирүүлэхээр заасан. Гэрээний хавсралт шалгана уу. Олон улсад гүйцэтгэгчээс санал авч гэрээний шатанд хэлэлцээр хийх туршлагад үндэслэсэн болно.
25	Эл ТМЗ нь Time Based эсвэл Lump Sum гэрээ юу гэдгийг тодорхойлох.	Төлбөрийн нөхцөлийг хэлэлцээрийн шатанд шийдвэрлэнэ. Гэрээний төсөл нь ажлын үр дүн (Deliverables, Milestone e.g)-тэй

		шууд уялдсан нэгдсэн үнэ (Lump sum)-ийн гэрээ байхаар бэлтгэгдсэн. Гэхдээ төслийн онцлогоос шалтгаалан та бүхэнд Lump sum болон Time based нөхцөлийг холимог санал байгаа тохиолдолд ирүүлж болно.
26	Барилгын ажил хугацаа уртсанаас, болон ТМЗ ээс үл хамааран төслийн хугацаа сунгагдах тохиолдолд ТМЗгийн гэрээг хэрхэн сунгах тухай тодруулах, шаардлагатай мэргэжилтнүүдийг сарын анх гэрээлсэн үнийн дүнгээр тооцож гэрээг сунгах төлбөрийн нэмэлтийг тооцохоор заалт гэрээнд нэмэх.	<p>Гэрээний төсөл нь ажлын үр дүн (Deliverables, Milestone e.g)-тэй шууд уялдсан нэгдсэн үнэ (Lump sum)-ийн гэрээ байхаар бэлтгэгдсэн.</p> <p>ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.</p> <p>ТЖББ-ийн Өгөгдлийн хүснэгтийн “ТШЗ 21.4-т” Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахаар заасан бөгөөд тохируулгын тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн “11.11-т Захиалагч гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэрээний үнийг тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлалыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэснийг анхаарах нь зүйтэй.</p>
27	Төслийн Захирлын АНУ PMP тэй байх шаардлагыг ИБУИНВУ ийн Chartered Engineer, Япон улсын Professional Engineer зэрэг зэргээр дүйцүүлэх боломжтой юу?	PMP зэрэгтэй дүйцэх мэргэжлийн зэргийг үүнээс харна уу. https://www.4pmti.com/learn/alternatives-pmp-certification/
28	Тендерийн үнийг "Lump sum" болон хугацаанд суурилсан хувьсах үнэ ашигласан холимог системээр бэлдэнэ. Үнийн дээд хязгаарыг тохирно.	Гэрээний төсөл нь ажлын үр дүн (Deliverables, Milestone e.g)-тэй шууд уялдсан нэгдсэн үнэ (Lump sum)-ийн гэрээ байхаар бэлтгэгдсэн. Гэхдээ төслийн онцлогоос шалтгаалан та бүхэнд Lump sum болон Time based нөхцөлийг холимог санал байгаа тохиолдолд ирүүлж болно,
29	Урьдчилгаа төлбөрийн талаар гэрээний хэлэлцээрийн явцад шийдвэрлэнэ.	Төлбөрийн нөхцөлийг хэлэлцээрийн шатанд шийдвэрлэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар урьдчилгаа төлбөр олгох тохиолдолд тендер оролцогч урьдчилгаа төлбөрөөс багагүй дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргахаар заасан. Урьдчилгаа төлбөр өгөхөөр тохиролцох нөхцөлд хүлээлгэн өгөх

		бичиг баримт (deliverables) болон ажлын үе шаттай (milestone) уялдуулж, эргэн төлөгдөх нөхцөлийг тодорхойлох (amortization) шаардлагатай.
30	Тендерийн баримт бичигт Даатгалын баримт бичгийг дурьдсан байна. “Хавсралт 8”-д даатгалын шаардлагыг дэлгэрэнгүй заасныг дурьджээ. Гэвч Хавсралт 8 бичиг баримтын бүрдэлд байсангүй. Даатгалын шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	Гэрээний тусгай нөхцөлийн 9.1.1-д Мэргэжлийн хариуцлагын даатгал (Professional indemnity insurance) нь гэрээний үнийн дүнгийн 10%-тай тэнцүү, Олон нийтийн хариуцлагын даатгал (Public liability insurance)] нь гэрээний үнийн дүнгийн 5%-тай тэнцүү байхаар заасан. Мөн Гэрээний ерөнхий нөхцөлийн 9.1.3-д оруулсан өөрчлөлтөөр РМС нь гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор дээрх даатгалыг хийлгэсэн болохыг нотлох баримт, гэрчилгээг ирүүлнэ гэж заасан байна.
31	Зөвлөх үйлчилгээний үнэ тарифын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч болох уу? Хэрэв Зөвлөх үйлчилгээний ажил төсөвт өртөгөөс давсан тохиолдолд нэмэгдэл зардлыг хэн хариуцах вэ?	Зөвлөх нь төсөвт өртөгт багтаан ажлыг хийж гүйцэтгэнэ. Гэрээний төсөл нь ажлын үр дүн (Deliverables, Milestone e.g)-тэй шууд уялдсан нэгдсэн үнэ (Lump sum)-ийн гэрээ байхаар бэлтгэгдсэн. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ. ТЖББ-ийн Өгөгдлийн хүснэгтийн “ТШЗ 21.4-т” Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахаар заасан бөгөөд тохируулгын тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн “11.11-т Захиалагч гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэрээний үнийг тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлалыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэснийг анхаарах нь зүйтэй.
32	Тендерийн баримт бичигт “Төсөл хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөө”-ний талаар удаа дараа дурьджээ. Энэ төлөвлөгөөг хэн бэлдэх вэ? Энэ төлөвлөгөөг хэзээ оролцогчдод өгөх вэ? Хэрэв “Төслийн Менежментийн Зөвлөх” энэ төлөвлөгөөг бэлдэх ёстой бол шаардлагыг дэлгэрэнгүй танилцуулж болох уу?	Техникийн тодорхойлолт (Үйлчилгээний даалгавар)-ын D.0-D.5-д төсөл хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөөнд хийж гүйцэтгэх ажлыг тодорхойлсон.
33	Тендерт Зөвлөх үйлчилгээний төслийн төсөвт өртөгийг дурьджээ. Энэ төсөвт өртөгт татвар хураамжийн талаар дурьдаагүй байна.	Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудлыг засгийн газрын түвшинд шийдвэрлэх тул тендерийн үнийн саналыг татварын хамт

	Татвар хураамжийг үнийн санал дээр хэрхэн тооцох талаар тодруулга өгнө үү. Татварын хөнгөлөлт байх уу?	тооцох бөгөөд хөнгөлөлт чөлөөлөлтийг гэрээ байгуулах шатанд шийдвэрлэнэ.
34	Тендерийн баримт бичигт зааснаар ТМЗ-ийн ажлын хөлсийг гэрээ байгуулах хэлэлцээрийн явцад тохируулна гэж заажээ. Тохируулгын шаардлагыг дэлгэрүүлж өгнө үү.	ТЖББ-ийн Өгөгдлийн хүснэгтийн “ТШЗ 21.4-т” Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахаар заасан бөгөөд тохируулгын тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн “11.11-т Захиалагч гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэрээний үнийг тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлалыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэснийг анхаарах нь зүйтэй.
35	ГЕН 10-т "Маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд шилжүүлж, эцэслэн шийдвэрлүүлнэ" гэсэн байна. Үүнийг "Арбитр эсвэл гуравдагч орны шүүхэд шилжүүлж, эцэслэн шийдвэрлүүлнэ" гэж өөрчлөх боломжтой юу?	ТЖББ-ийн VI бүлэг “Гэрээний нөхцөл” хэсэгт олон улсын тендер шалгаруулалтыг харгалзан Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ноос эрхлэн гаргадаг Зөвлөх үйлчилгээний гэрээ (White book, 2017)-ний нөхцөлийг хэрэглэхээр заасан. Тус бүлгийн Гэрээний тусгай нөхцөлийн В хэсгийн 10-т “Маргаан шийдвэрлэх, арбитр: маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд шилжүүлж, эцэслэн шийдвэрлүүлнэ гэж заасан. ТЖББ-ын ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ үү.
36	ГТН 1.4.2 болон 1.4.3-т гэрээ болон харилцах хэлийг "Монгол болон Англи (зөрүү үүсвэл Монгол хэлийг баримтлана)" гэсэн байна. Гадаадын этгээд шалгарсан тохиолдолд "Монгол болон Англи (зөрүү үүсвэл Англи хэлийг баримтлана)" гэж өөрчлөх боломжтой юу?	ТЖББ-ийн VI бүлэг “Гэрээний нөхцөл” хэсэгт олон улсын тендер шалгаруулалтыг харгалзан Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ноос эрхлэн гаргадаг Зөвлөх үйлчилгээний гэрээ (White book, 2017)-ний нөхцөлийг хэрэглэхээр заасан. Тус бүлгийн Гэрээний тусгай нөхцөлийн А хэсгийн 1.4.2-т гэрээнд баримтлах албан ёсны хэл нь Монгол болон Англи хэл байх бөгөөд зөрүү үүсвэл Монгол хэлийг баримтлахаар заасан болно.